

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/029/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн захирал: М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/314
танай _____-ны № _____-т

ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ-
ЫН ДАРГА Г.МӨНХЗУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдийн сургуулийн өмнөх боловсролын 102 цэцэрлэг, ерөнхий боловсролын 21 сургуулийн хүүхэд багачуудыг хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангаж ажилласан байна.

Нийслэлийн Статистикийн газраас гаргадаг үнийн мэдээлэлтэй тус байгууллагаас харилцагчдаа нийлүүлж буй 15 төрлийн бүтээгдэхүүний үнийг харьцуулан судлахад тус байгууллагын олж бэлтгэсэн үнэ нь зах зээлийн үнээс 9.4 хувийн хямд байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 12,421,643.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 12,244,971.3 мянган төгрөгийг зарцуулж, 176,672.6 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2023 оны оны цэвэр ашгаас 697.1 мянган төгрөгийн ноогдол ашгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 зорилтын

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Work\1425010164

хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 89.1 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	66,493,139.12	86,685,828.47
1.1.2	Дансны авлага	1,741,330.00	14,794,030.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	25,806,262.90
1.1.6	Бараа материал	208,503,655.77	143,820,226.17
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	2,131,330.00	5,871,936.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	278,869,454.89	276,978,283.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	155,404,207.10	355,185,433.94
1.2.2	Биет бус хөрөнгө	36,768,120.00	36,768,120.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	192,172,327.10	391,953,553.94
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	471,041,781.99	668,931,837.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	150,599,714.77	15,477,981.73
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	150,599,714.77	15,477,981.73
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	436,287.06
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	436,287.06
2.2	Өр төлбөрийн нийт дүн	150,599,714.77	15,914,268.79
2.3	Эздийн өмч	155,762,196.93	312,902,196.93
2.3.1	Өмч: - төрийн	155,762,196.93	312,902,196.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	21,679,471.32	19,511,524.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,768,120.00	36,768,120.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	103,717,209.70	107,163,162.02
2.3.10	Тайлант үеийн ашиг (алдагдал)	2,515,069.27	176,672,565.55
2.3.11	Эздийн өмчийн дүн	320,442,067.22	653,017,568.69
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	471,041,781.99	668,931,837.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,718,611,366.82	12,412,726,380.01
2	Борлуулалтын өртөг	8,877,038,266.48	11,112,824,218.33
3	Нийт ашиг (алдагдал)	841,573,100.34	1,299,902,161.68
5	Хүүний орлого	429,977.29	462,437.97
8	Бусад орлого	26,333,494.32	8,455,072.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	838,022,451.03	1,086,992,469.67
12	Бусад зардал	24,767,639.56	22,971,916.55
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,546,481.36	198,855,285.79
19	Орлогын татварын зардал	3,031,412.09	22,182,720.24
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,515,069.27	176,672,565.55
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,515,069.27	176,672,565.55
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	(2,167,947.13)
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	(2,167,947.13)
24	Орлогын нийт дүн	2,515,069.27	174,504,618.42

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022-12-31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	170,742,989.70	384,952,777.95
3	Залруулсан үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	170,742,989.70	384,952,777.95
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,515,069.27	2,515,069.27
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(67,025,780.00)	(67,025,780.00)
9	2023-12-31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	106,232,278.97	320,442,067.22
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,685,423.05	1,685,423.05
11	Залруулсан үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.00	107,917,702.02	322,127,490.27
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	176,672,565.55	176,672,565.55
14	Өмчид гарсан өөрчлөлт	157,140,000.00	-	-	-	157,140,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(754,540.00)	(754,540.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(2,167,947.13)	-	-	(2,167,947.13)
17	2024-12-31-ний үлдэгдэл	312,902,196.93	19,511,524.19	36,768,120.00	283,835,727.57	653,017,568.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,734,543,528.32	13,647,428,992.03
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,687,927,919.00	13,629,403,178.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,656,892,815.76	13,547,413,877.92
	Ажиллагчдад төлсөн	497,894,476.15	620,642,407.37
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	130,538,287.71	175,787,319.23
	Бараа материал худалдан авахад төлсөн	9,265,974,340.00	11,555,403,885.49
	Ашиглалтын зардалд төлсөн	61,720,028.00	84,632,186.19
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	38,327,987.50	41,575,061.00
	Татварын байгууллагад төлсөн	593,839,758.97	991,635,428.01
	Даатгалын төлбөрт төлсөн	-	671,760.00
	Бусад мөнгөн зарлага	68,597,937.43	77,065,830.63
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	77,650,712.56	100,015,114.11
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	429,977.29	462,437.97
	Хүлээн авсан хүүний орлого	429,977.29	462,437.97
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,464,000.00	79,605,772.73
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,464,000.00	79,605,772.73
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,034,022.71)	(79,143,334.76)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	60,323,202.00	679,090.00
	Төлсөн ногдол ашиг	60,323,202.00	679,090.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(60,323,202.00)	(679,090.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,293,487.85	20,192,689.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,199,651.27	66,493,139.12
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	66,493,139.12	86,685,828.47

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Д.д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	
				Төгрөгөөр	Хувиар
1	Нийт орлого	11,465,951.1	12,421,643.9	(955,692.8)	108.34
2	Борлуулалтын орлого	11,464,251.1	12,412,726.4	(948,475.3)	108.27
3	Бусад орлого	1,700.0	8,917.5	(7,217.5)	524.56
4	Нийт зардал	11,456,520.9	12,222,788.6	(766,267.7)	106.69
5	ББӨ	10,208,594.0	11,112,824.2	(904,230.2)	108.86
6	Үйл ажиллагааны зардал				
7	Цалин	770,135.5	772,215.4	(2,079.8)	100.27
8	Хоол унааны зардал	88,499.4	-	88,499.4	-
9	Нийгмийн даатгалын шимтгэл	107,329.4	92,676.3	14,653.1	86.35
10	Шуудан холбоо	3,938.4	4,525.7	(587.3)	114.91
11	Цахилгаан	15,369.5	13,163.7	2,205.8	85.65
12	Шатахуун	28,538.0	25,568.5	2,969.6	89.59
13	Бичиг хэрэг	4,366.4	4,638.4	(272.0)	106.23
14	Хөдөлмөр хамгаалал	9,600.0	9,808.0	(208.0)	102.17
15	Ашиглалтын зардал	5,152.0	5,813.7	(661.7)	112.84
16	Хангамжийн материал	11,852.0	16,044.4	(4,192.4)	135.37
17	Засварын зардал	19,000.0	19,829.7	(829.7)	104.37
18	Түрээсийн зардал	42,000.0	41,045.5	954.6	97.73
19	Элэгдлийн зардал	40,024.6	36,964.5	3,060.1	92.35
20	Сэлбэг хэрэгсэл	14,270.0	17,083.6	(2,813.6)	119.72
21	Сургалтын зардал	11,685.0	1,495.0	10,190.0	12.79
22	Албан томилолт	12,000.0	-	12,000.0	-
23	Бусад зардал	22,220.4	25,042.1	(2,821.7)	112.70
24	Татвар, даатгал	2,724.4	1,078.1	1,646.3	39.57
25	Үйл ажиллагааны зардлын дүн	1,208,705.0	1,086,992.5	121,712.5	89.93
26	Үйл ажиллагааны бус зардал	39,221.9	22,971.9	16,250.0	58.57
27	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,430.2	198,855.3	(189,425.1)	2,108.71
28	Орлогын татварын зардал	943.0	22,182.7	(21,239.7)	2,352.30
29	Цэвэр ашиг (алдагдал)	8,487.2	176,672.6	(168,185.4)	2,081.64
30	Бусад дэлгэрэнгүй орлого	-	(2,168.0)	2,168.0	-
31	Нийт дэлгэрэнгүй орлого	8,487.2	174,504.6	(166,017.5)	2,056.10
32	Нийт авлага	-	14,794.0	(14,794.0)	-
33	Нийт өглөг	-	15,979.9	(15,979.9)	-
34	Хөрөнгө худалдан авалт	82,560.0	79,605.8	2,954.2	96.42

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 10,091.9 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Нийт 29,762.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 28,125.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,637.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилтанд цалин, цалингийн нэмэгдэл, урамшуулал, хоолны унааны мөнгийг зөрүүтэй тооцоолж илүү олгосон.	1	4,008.5	-	0.0	1	4,008.5	1	4,008.5				
"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 9 дахь заалтыг зөрчин захирлын шийдвэргүйгээр өртгөөр нь бараа олгосон.	1	2,086.6	-	0.0	1	2,086.6	1	2,086.6				
НББОУС 12 "Орлогын албан татвар"-г заасны дагуу хүлээн зөвшөөрвөл зохих хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгээгүй байна.	1	2,167.9	-	0.0	1	2,167.9	1	2,167.9				
НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 дахь заалтуудыг зөрчин "ажиллагсдад өгсөн барааг" НӨАТ ногдуулан тайлагнаагүй байна..	1	835.6	1	835.6	-	0.0	1	835.6				
Агуулах дахь барааны үлдэгдлийг түүвэр сонголтод хамруулан тулгахад 4 бараа түгээлтийн ажил бүрэн дуусгавар болж баталгаажуулалт хийгдээгүйтэй холбоотой зөрүү илэрсэн.	1	17.0	1	17.0			1	17.0				
НӨАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4, 7.2.13 дахь заалтуудыг зөрчин холбогдох орлогыг НӨАТ-ын тайланд тайлагнаагүй байна.	1	930.0	-	0.0	1	930.0	1	930.0				
ҮХ-ийн дахин үнэлгээний нэмэгдлээс зөвшөөрсөн хойшлогдсон татварын өр төлбөрөөс ОАТ-ын өрт бүртгэсэн боловч ААНОАТ-ын тайланд нөлөөллийг тусгаагүй.	1	46.2	-	0.0	1	46.2	1	46.2				
Дүн	7	10,091.9	2	852.6	5	9,239.3	7	10,091.9	-	0.0	-	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох ашиглах эрхтэй хөрөнгө, өр төлбөр, хүүгийн зардал, хорогдуулгын зардлыг бүртгээгүй.	1	1,637.2					1	1,637.2				
Худалдан авах ажиллагааг харьцуулалтын үнийн аргаар зохион байгуулаагүй, босго үнийг баримтлаагүй	1	28,125.3			1	28,125.3						
Дүн	1	29,762.5	-	0.0	1	28,125.3	1	1,637.2	-	0.0	-	0.0

АДБОУС 4000. 16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулсан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	1								1			
Дүн	-	0.0	-	0.0	-	0.0	-	0.0	-	0.0	-	0.0

5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТБОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			